НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Багануур дүүргийн Боловсролын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** НТАГ-2026/217/НА-СТА-ТШЗ

Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр

Утас: 327734 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Алтанцэцэг

Утас: 315093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn

Ахлах аудитор: Н.Баттогоо

Утас: 325093 Цахим хаяг: battogoon@audit.gov.mn

Аудитор: Т.Мөнхцацрал

Цахим хаяг: munkhtsatsralt@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2026 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 72

танай ____________-ны № ____________-т

НИЙСЛЭЛИЙН БАГАНУУР ДҮҮРГИЙН БОЛОВСРОЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА Ц.ОНОНТУНГАЛАГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Багануур дүүргийн Боловсролын хэлтсийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Нэмэлт санхүүжилтийн дансанд Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах нөөц хөрөнгөөс 29.7 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 2.8 сая төгрөг, нийт 32.5 сая төгрөгийг бүрдүүлж, зарцуулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тус хэлтэс нь "БИ БАГШ" удирдах ажилтны мэргэжлийг дээшлүүлэх, ур чадварын уралдааныг зохион байгуулснаар байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ 8.14 хувиар өссөн байна.

1426050145

**Бусад асуудал**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 88.4 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

C:\Users\narangua.j\Desktop\Бичиг хэрэг 2026\2026\word\ywsan bichig\2026.02.25 Dugnelt -.docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

***/төгрөгөөр/***

| Данс | Балансын зүйл | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 4 | | |
| 32 | БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | | | |
| 33 | АВЛАГА | 5 | 1,454,064.20 | 1,429,064.20 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | | 1,454,064.20 | 1,429,064.20 |
| 33101 | Цалингийн авлага | | 1,454,064.20 | 1,429,064.20 |
| 34 | УРЬДЧИЛГАА | | | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 6 | 3,946,497.00 | 3,946,497.00 |
| 35400 | Хангамжийн материал | | 3,946,497.00 | 3,946,497.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | | 3,946,497.00 | 3,946,497.00 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | | | |
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | | 5,400,561.20 | 5,375,561.20 |
| 37 | УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | | | |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 7 | 60,645,176.93 | 38,917,974.05 |
| 39200 | Биет хөрөнгө | | 60,645,176.93 | 38,917,974.05 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | | 82,540,648.00 | 85,200,558.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж | | -32,306,361.72 | -53,855,496.72 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | | 17,839,965.04 | 17,839,965.04 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл - Тавилга | | -7,429,074.39 | -10,267,052.27 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | | 600,000.00 | 600,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл - Бусад биет бус хөрөнгө | | -600,000.00 | -600,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | | 60,645,176.93 | 38,917,974.05 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | | 66,045,738.13 | 44,293,535.25 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 9 | | 602,650.00 |
| 41300 | Өглөг | | | 602,650.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | | 162,650.00 |
| 413206 | Шуудан холбооны өглөг | | | 162,650.00 |
| 41360 | Бусад өглөг | | | 440,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | | | 440,000.00 |
| 42 | УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 10 | | |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | | | 602,650.00 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | | 66,045,738.13 | 43,690,885.25 |
| 51101 | -Төрийн | | 59,031,226.00 | 59,031,226.00 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | | 7,014,512.13 | -15,340,340.75 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | | 14,855,107.85 | 7,014,512.13 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | -7,840,595.72 | -22,354,852.88 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 66,045,738.13 | 43,690,885.25 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | | 66,045,738.13 | 44,293,535.25 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

***/төгрөгөөр/***

| Данс | Балансын зүйл | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|---|
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | | | |
| 13 | ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2 | 281,567,500.00 | 331,340,700.00 |
| 1310 | Улсын төсвөөс | | 260,798,700.00 | 298,774,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 260,798,700.00 | 298,774,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 20,768,800.00 | 32,566,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | | 19,988,800.00 | 29,718,400.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | | 780,000.00 | 2,847,600.00 |
| 12 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО | | 61,880,245.00 | 1,324,541.00 |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | | 61,880,245.00 | 1,324,541.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 15,028,245.00 | 1,274,541.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал | | 46,852,000.00 | 50,000.00 |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 2 | 343,447,745.00 | 332,665,241.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 351,288,340.72 | 355,020,093.88 |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 333,579,552.05 | 315,433,793.51 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | | 205,042,800.00 | 227,440,745.97 |
| 210101 | Үндсэн цалин | | 112,215,825.29 | 115,655,127.44 |
| 210102 | Нэмэгдэл | | 41,961,150.71 | 50,417,546.36 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | | 32,011,304.00 | 44,940,085.42 |
| 210104 | Урамшуулал | | 18,854,520.00 | 16,427,986.75 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 23,914,017.33 | 25,436,388.66 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 16,320,802.53 | 17,663,788.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 1,898,053.70 | 1,943,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 949,276.85 | 971,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 949,276.85 | 971,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 3,796,607.40 | 3,886,300.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 66,398,194.00 | 13,637,315.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 2,236,500.00 | 9,591,690.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 6,938,800.00 | 1,490,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 196,394.00 | 586,725.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 10,394,500.00 | 1,968,900.00 |
| 210409 | Бараа материал шилжүүлсний зардал | | 46,632,000.00 | |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 50,000.00 | |
| 210702 | Дотоод албан томилолт | | 50,000.00 | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 440,000.00 | 440,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 440,000.00 | 440,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 37,734,540.72 | 48,479,343.88 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 13,098,000.00 | 23,977,600.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | | 2,000,000.00 | 1,500,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | | 22,636,540.72 | 23,001,743.88 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | | 17,708,788.67 | 39,586,300.37 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 15,576,900.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг | | 15,378,300.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 198,600.00 | |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 2,131,888.67 | 39,586,300.37 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 1,891,888.67 | 39,586,300.37 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 240,000.00 | |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | | |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 3 | 351,288,340.72 | 355,020,093.88 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН | | (7,840,595.72) | (22,354,852.88) |
| 14 | ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ОРЛОГО | | | |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | | | |
| 23 | Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл | | | |
| 24 | Гадаад зээлийн үндсэн төлбөр | | | |
| 25 | Гадаад валютын ханшийн зөрүү | | | |
| 5 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | | | |
| 6 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН | | (7,840,595.72) | (22,354,852.88) |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

***/төгрөгөөр/***

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | | |
| 13 | ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 281,567,500.00 | 331,340,700.00 |
| 1310 | Улсын төсвөөс | 260,798,700.00 | 298,774,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 260,798,700.00 | 298,774,700.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 20,768,800.00 | 32,566,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | 19,988,800.00 | 29,718,400.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 780,000.00 | 2,847,600.00 |
| 12 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 281,567,500.00 | 331,340,700.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 281,567,500.00 | 331,340,700.00 |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 263,858,711.33 | 291,754,399.63 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 205,067,800.00 | 227,415,745.97 |
| 210101 | Үндсэн цалин | 112,240,825.29 | 115,630,127.44 |
| 210102 | Нэмэгдэл | 41,961,150.71 | 50,417,546.36 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 32,011,304.00 | 44,940,085.42 |
| 210104 | Урамшуулал | 18,854,520.00 | 16,427,986.75 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 23,914,017.33 | 25,436,388.66 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,320,802.53 | 17,663,788.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,898,053.70 | 1,943,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 949,276.85 | 971,600.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 949,276.85 | 971,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,796,607.40 | 3,886,300.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 9,409,694.00 | 4,836,265.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 881,200.00 | 1,003,290.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 6,330,000.00 | 1,440,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 196,394.00 | 424,075.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 207,500.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,794,600.00 | 1,968,900.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 50,000.00 | |
| 210702 | Дотоод албан томилолт | 50,000.00 | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 440,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 440,000.00 | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,977,200.00 | 34,066,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,753,000.00 | 32,566,000.00 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,224,200.00 | 1,500,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 17,708,788.67 | 39,586,300.37 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 15,576,900.00 | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг | 15,378,300.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 198,600.00 | |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 2,131,888.67 | 39,586,300.37 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,891,888.67 | 39,586,300.37 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 240,000.00 | |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН | 281,567,500.00 | 331,340,700.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 14 | ҮЙЛ АЖИЛАГААНЫ БУС ОРЛОГО | | |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | | |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | | |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 9 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | | |
| 23 | Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл | | |
| 24 | Гадаад зээлийн үндсэн төлбөр | | |
| 25 | Гадаад валютын ханшийн зөрүү | | |
| 10 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | | |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII) | | |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 14 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 15 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

***/төгрөгөөр/***

| Код | Үзүүлэлт | Засгийн хөрөнгө оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 59,031,226.00 | | 14,855,107.85 | 73,886,333.85 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 59,031,226.00 | | 14,855,107.85 | 73,886,333.85 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | | | |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | | | | |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | | | | |
| 7 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | |
| 8 | Зарласан ноогдол ашиг | | | | |
| 9 | Тайлант үеийн үр дүн | | | (7,840,595.72) | (7,840,595.72) |
| 10 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | | | | |
| **11** | 2025 оны 1-р сарьн 1-нээрх үлдэгдэл | 59,031,226.00 | | 7,014,512.13 | 66,045,738.13 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 59,031,226.00 | | 7,014,512.13 | 66,045,738.13 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | | | |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | |
| 18 | Зарласан ноогдол ашиг | | | | |
| 19 | Тайлант үеийн үр дүн | | | (22,354,852.88) | (22,354,852.88) |
| 20 | 2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 59,031,226.00 | | (15,340,340.75) | 43,690,885.25 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

***/төгрөгөөр/***

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 71808 | Боловсрол, шинжлэх ухааны бодлого удирдлага | 298,774,700.00 | 259,188,399.63 | 39,586,300.37 | 86.7 |
| 80101 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 298,774,700.00 | 259,188,399.63 | 39,586,300.37 | 86.7 |
| 00012 | Татварын бус орлого | 298,774,700.00 | 259,188,399.63 | 39,586,300.37 | 86.7 |
| 12200 | Тусламжийн орлого | 298,774,700.00 | 259,188,399.63 | 39,586,300.37 | 86.7 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 298,774,700.00 | 259,188,399.63 | 39,586,300.37 | 86.7 |
| 00002 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 298,774,700.00 | 259,188,399.63 | 39,586,300.37 | 86.7 |
| 00021 | УРСГАЛ ЗАРДАЛ | 298,774,700.00 | 259,188,399.63 | 39,586,300.37 | 86.7 |
| 00210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 298,774,700.00 | 259,188,399.63 | 39,586,300.37 | 86.7 |
| 02101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 255,515,000.00 | 227,415,745.97 | 28,099,254.03 | 89.0 |
| 210101 | Үндсэн цалин | 143,117,100.00 | 115,630,127.44 | 27,486,972.56 | 80.7 |
| 210102 | Нэмэгдэл | 78,546,300.00 | 50,417,546.36 | 28,128,753.64 | 64.1 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 22,054,500.00 | 44,940,085.42 | (22,885,585.42) | 103.7 |
| 210104 | Урамшуулал | 11,797,100.00 | 16,427,986.75 | (4,630,886.75) | 39.2 |
| 02102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 33,389,300.00 | 25,436,388.66 | 7,952,911.34 | 76.1 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,616,700.00 | 17,663,788.66 | 7,952,911.34 | 68.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,943,100.00 | 1,943,100.00 | - | 00.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 971,600.00 | 971,600.00 | - | 00.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 971,600.00 | 971,600.00 | - | 00.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,886,300.00 | 3,886,300.00 | - | 00.0 |
| 02104 | Хангамж, бараа материалын зардал | 6,489,900.00 | 4,836,265.00 | 1,653,635.00 | 74.5 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,694,900.00 | 1,003,290.00 | 691,610.00 | 59.2 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,440,000.00 | 1,440,000.00 | | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 774,900.00 | 424,075.00 | 350,825.00 | 54.7 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 430,000.00 | - | 430,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,150,100.00 | 1,968,900.00 | 181,200.00 | 91.5 |
| 02108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж | 394,200.00 | - | 394,200.00 | - |
| 210807 | Газрын төлбөр | 394,200.00 | | 394,200.00 | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,986,300.00 | 1,500,000.00 | 1,486,300.00 | 50.2 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,986,300.00 | 1,500,000.00 | 1,486,300.00 | 50.2 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 6.00 | 6.00 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 5.00 | 5.00 | - | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

/***төгрөгөөр***/

| Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I) | 32,566,000.00 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 32,566,000.00 |
| БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 32,566,000.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 32,566,000.00 |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 32,566,000.00 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 32,566,000.00 |
| ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 32,566,000.00 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 32,566,000.00 |
| ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | 29,718,400.00 |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 2,847,600.00 |
| НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 602.6 мянган төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн 602.6 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Төсвийг зөв зохистой удирдаагүй, жилийн төсөвтөө багтаан өр төлбөрийг бүрэн барагдуулаагүй байна. | 1 | 602.6 | | | | | 1 | 602.6 | | | | |
| **Дүн** | **1** | **602.6** | | | | | **1** | **602.6** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс: Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Шилэн данстай холбоотой зөрчил | | | | | | | | | | | | |
| Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад орлого, зарлагын таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 4 гүйлгээ , зардлын 5 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 3 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| **Дүн** | **1** | **-** | | | **1** | **-** | | | | | | |

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 31/А0371847 Улаанбаатар хот

НТАГ-2026/817/НА-СТА-ТШЗ

**Зөрчил арилгах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Багануур дүүргийн Боловсролын хэлтсийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад орлого, зарлагын таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 4 гүйлгээ, зардлын 5 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 3 шийдвэрийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4-д *"Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ."* 6.4.5-д *"цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;"* 6.4.8-д *"бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;"* гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө."*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан *"Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"*-ын *4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол"* заалтад заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нийслэлийн Багануур дүүргийн Боловсролын хэлтсийн дарга Ц.Онontунгалаг, нягтлан бодогч Б.Март нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Г.НАНДИНЖАРГАЛ

АУДИТОР Т.МӨНХЦАЦРАЛ

1426990147